



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ
/2020 оны IV улирал/

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

/2020 оны IV улирал/

Тайланд карт гаргагч, хүлээн авагч 12 банк, карт хүлээн авагч 1 байгууллагын төлбөрийн карт, төхөөрөмж, бусад төлбөрийн хэрэгсэл, Монголбанкаар дамжсан их, бага дүнтэй гүйлгээний мэдээллийг сүүлийн 3 жилийн байдлаар нэгтгэж, үзүүлэв. Картын хэрэглээг хот ба орон нутгаар, идэвхтэй болон идэвхгүй ашиглагдаж байгаа гэж ангилахаас гадна картын нэр төрлөөр (Ү карт, Виза, Мастеркарт, ЮнионПэй, Американ Экспресс, ЖейСиБи) тус бүрт нь авч үзэв. Мөн картын үйлчилгээнд ашиглагдаж буй төхөөрөмжийн тоо (ПОС, МПОС, ПОБ, АТМ¹, CDM², CRM³, Цахим худалдаа, Киоск⁴), карт ашиглан хийсэн гүйлгээний тоо, дүнг карт гаргагч, хүлээн авагч банкаар, өөрийн болон бусад клирингийн системд хийгдсэн байдлаар ангилж үзүүллээ.


Төлбөрийн системийн оролцогч хоорондын бага дүнтэй ба багцын гүйлгээний Автомат клиринг хаус (АСН+) систем болон их дүнтэй гүйлгээний Банксүлжээ системээр дамжсан гүйлгээний тоо, дүнг улирлаар авч үзэн, өөрчлөлт ба нийт гүйлгээнд эзлэх хувь хэмжээг тодорхойлов. Тайланд дурдагдсан

тоон мэдээллийг нэгтгэсэн хүснэгтийг хавсралтаар үзүүлэв.

1. ТӨЛБӨРИЙН КАРТЫН ХЭРЭГЛЭЭ

• Картын тоо

Банкуудын гаргасан картын тоо 2020 оны IV улирлын байдлаар 4.1 сая ширхэг байгаа нь өмнөх оны IV улирлын үзүүлэлттэй харьцуулахад 329.9 мянган ширхэгээр буюу 8.8 хувиар өссөн байна. Нийт картын 45.7 хувь буюу 1.9 сая карт идэвхтэй ашиглагдаж байгааг Зураг 1-т үзүүлэв. Идэвхтэй ашиглагдаж байгаа картын тоо өмнөх оны IV улирлын үзүүлэлтээс 36.2 мянга буюу 1.9 хувиар буурсан байна (Хүснэгт I).



¹ АТМ зөвхөн бэлэн мөнгөний зарлага хийнэ

² CDM зөвхөн бэлэн мөнгөний орлого хийнэ

³ CRM бэлэн мөнгөний орлого, зарлага хийнэ

⁴ ПОС төхөөрөмжтэй

Картын хэрэглээний тайлан

(өссөн дүнгээр)

Хүснэгт I	2019 он, IV улирал	2020 он, IV улирал	Өсөлт/бууралт (2019-IV/2020-IV)	
			Тоо	Хувь
Картын тоо	3,748,025	4,077,893	329,868	8.80%
Идэвхтэй ашиглагдаж буй картын тоо	1,899,509	1,863,290	(36,219)	-1.91%

Картын хэрэглээг аймаг, хотоор авч үзвэл 2020 оны IV улирлын байдлаар орон нутагт 1.4 сая ширхэг төлбөрийн карт ашиглагдаж байгаа нь өмнөх оны IV улирлын үзүүлэлтээс 214 мянган ширхэг буюу 18.2 хувиар нэмэгдсэн байна. Хотуудын хувьд карт эзэмшигчдийн тоо 2.7 сая ширхэг байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 115.8 мянган ширхэг буюу 4.5 хувиар өссөн байгааг Зураг 2-т үзүүлэв.



Хүснэгт II -оос үзэхэд өмнөх оны жилийн эцсийн байдлаар нийт карт эзэмшигчдийн 68.6% нь хот, 31.4% нь орон нутагт байсан бөгөөд үүнийг энэ оны жилийн эцсийн

үзүүлэлтэй харьцуулахад 65.9% ба 34.1% болон өөрчлөгдөж, орон нутаг дахь карт эзэмшигч нэмэгдсэн байна.


Картын хэрэглээний тайлан

Өссөн дүнгээр

Хүснэгт II	2019 он, IV улирал	2020 он, IV улирал	Өсөлт/бууралт (2019-IV/2020-IV)	
			Тоо	Хувь
Хотууд	2,571,579	2,687,406	115,827	4.50%
Эзлэх хувь	68.6	65.9		
Бусад аймгууд	1,176,446	1,390,487	214,041	18.19%
Эзлэх хувь	31.4	34.1		

Банкуудын зүгээс техник технологийн дэвшлийг ашиглаж, үйлчилгээний шинэ төрөл, хэлбэрийг нэвтрүүлснээр санхүүгийн байгууллагын үйлчилгээг карт эзэмшигчид хүргэх боломж нэмэгдэж байгаа нь орон нутагт амьдарч буй иргэдийн картын тоо өсөх нэг шалтгаан болж байна.

Банкууд 6 төрлийн картыг өөрийн банкны оноосон нэрээр гаргаж байгаа ба эдгээрийн тоо хэмжээг төрөл тус бүрээр нь хавсралтын Хүснэгт 16-д үзүүлэв. Тайлант хугацаанд 2.6 сая ширхэг буюу нийт картын 63.6 хувийг үндэсний брэнд ₮ карт, 20.3 хувийг ЮнионПэй карт, 12.7 хувийг Виза карт тус тус эзэлж байна. Харин Мастеркарт, Американ Экспресс болон ЖейСиБи картууд хамгийн бага буюу 0.1-ээс 3.0 хүртэлх хувийг эзэлж байгааг Зураг 3-т үзүүлэв. Эдгээр үзүүлэлтийг өмнөх оны




жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад Амекс картын тоо 8.2 хувиар, ЖейСиБи картын тоо 5.0 хувиар, ₮ картын тоо 0.2 хувиар тус тус буурсан. Тайлант хугацаанд Мастеркарт картын тоо 61.8 хувиар, Виза картын тоо 32.2 хувиар, ЮнионПэй картын тоо 24.6 хувиар, өмнөх оны үзүүлэлтээс тус тус нэмэгдсэн байна (хавсралтын Хүснэгт 1в).

• Төхөөрөмжийн тоо

Энэ оны жилийн эцсийн байдлаар нийт төхөөрөмжийн 88.7 хувийг ПОС, 3.7 хувийг ПОБ, 2.6 хувийг МПОС, 2.0 хувийг CRM, 1.4 хувийг АТМ, мөн 1.4 хувийг Цахим худалдаа эзэлж байгаа бол бусад төхөөрөмжүүд 0.1-ээс 0.3 хувийг тус тус эзэлж байгааг Зураг 4-д үзүүлэв. Өмнөх оны жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад

Киоск (пос-той) болон Цахим худалдаа хамгийн их буюу 61.9 ба 43.9 хувиар өссөн байгаа нь өөртөө үйлчилж, үйлчилгээ авах болон төхөөрөмж ба интернет ашиглан картаар төлбөр хийх боломжтой цахим худалдааны үйлчилгээ манай улсад хурдацтайгаар хөгжиж буйг харуулж байна (хавсралтын Хүснэгт 2б).



Орон даяар хэрэглэгдэж буй нийт төхөөрөмжийн тоог өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 10.8 мянган ширхэг буюу 15.7 хувиар өссөнөөр 79.8 мянган ширхэг болоод байна (хавсралтын Хүснэгт 2б).


Төхөөрөмжийн тоог хот, аймаг тус бүрээр харьцуулж үзэхэд улсын хэмжээний нийт төхөөрөмжийн 23.8 хувь нь орон нутагт, 76.2 хувь нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод байршиж байгаа нь хүн амын

төвлөрөлтэй холбоотойгоор төлбөрийн картын хэрэглээ хотуудад төвлөрсөн хэвээр байгааг харуулж байна (хавсралтын Хүснэгт 2а).

• Гүйлгээний тоо, дүн

Банкуудын өөрийн гаргасан картаар өөрийн банкны сүлжээ, ҮЦГТ-ийн нэгдсэн сүлжээ болон гадаад сүлжээнд 8.8 их наяд төгрөгийн 124.9 сая ширхэг гүйлгээ 2020 оны IV улиралд хийгдсэн нь өмнөх III улирлын үзүүлэлтээс 1.7 их наяд төгрөгийн 20.8 сая ширхэг гүйлгээгээр буурсан үзүүлэлттэй байна. КОВИД-19 цар тахлын улмаас Монгол Улсын хэмжээнд хатуу хөл хорио тогтоосонтой холбоотойгоор гүйлгээний тоо 14.3 хувь, гүйлгээний дүн 15.9 хувь буурсан байна. Өмнөх оны IV улирлаас гүйлгээний дүн нь 18.2 хувиар

буурсан ч, гүйлгээний тоо нь 2.9 хувийн өсөлттэй байна (хавсралтын Хүснэгт 3а,б). Бүх сүлжээнд хийгдсэн картын гүйлгээг картын төрлөөр нь авч үзэхэд үндэсний брэнд ₮ карт нийт гүйлгээний тооны 62.1 хувийг, гүйлгээний дүнгийн 54.4 хувийг дангаараа эзэлж байгаа бол, ЮнионПэй карт нийт гүйлгээний тооны 22.9 хувийг, дүнгийн 23.3 хувийг, Виза карт нийт гүйлгээний 13.8 хувь, дүнгийн 21.3 хувийг эзэлж байна. Харин Мастеркарт, Американ экспресс болон ЖейСиБи картууд харьцангуй бага буюу гүйлгээний тооны 0.03-аас 1.2, дүнгийн 0.04-өөс 0.9 хувийг тус тус эзэлж байгааг Зураг 5-д үзүүлэв.



Өөрийн, дотоодын бусад байгууллагын, гадаад байгууллагын гаргасан картыг өөрийн сүлжээнд хүлээн авсан амжилттай гүйлгээний тайлан - Төхөөрөмжийн төрлөөр (бэлэн, бэлэн бус) мянган ширхэг, тэрбум төгрөг

Хүснэгт III	Бэлэн бус										Нийт	
	ПОС		МПОС		Цахим худалдаа		ATM/CRM		КИОСК (пос-той)			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2020-IV улирал	98,950.79	2,304.26	12.32	0.56	485.18	19.97	3,585.40	2,391.02	76.60	1.25	103,110.29	4,717.07
2019-IV улирал	80,285.65	2,005.78	81.99	1.37	290.73	13.04	4,937.45	3,188.31	73.20	2.22	85,669.01	5,210.72
Өөрчлөлт	18,665.14	298.49	-69.66	-0.81	194.45	6.94	-1,352.05	-797.29	3.39	-0.97	17,441.28	-493.64
Өөрчлөлт %	23.25%	14.88%	-84.97%	-58.86%	66.89%	53.20%	-27.38%	-25.01%	4.64%	-43.65%	20.36%	-9.47%

мянган ширхэг, тэрбум төгрөг

Хүснэгт IV	Бэлэн								Нийт	
	ПОС		ПОБ		АТМ/CRM зарлага		CDM/CRM орлого			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2020-IV улирал	122.82	6.73	317.31	76.08	14,407.43	2,148.30	4,613.21	1,710.17	19,460.77	3,941.28
2019-IV улирал	171.51	7.22	421.11	119.38	20,855.23	2,835.85	5,793.92	2,175.95	27,241.76	5,138.41
Өөрчлөлт	-48.68	-0.49	-103.80	-43.30	-6,447.81	-687.55	-1,180.70	-465.78	-7,781.00	-1,197.13
Өөрчлөлт %	-28.39%	-6.81%	-24.65%	-36.27%	-30.92%	-24.24%	-20.38%	-21.41%	-28.56%	-23.30%


Төлбөрийн системийн оролцогчид өөрийн гаргаснаас гадна дотоодын бусад байгууллага, гадаад байгууллагын гаргасан картыг өөрийн сүлжээнд карт уншигч төхөөрөмжөөр дамжуулан хүлээн авдаг. Тайлант хугацаанд нийт 8.7 их наяд төгрөгийн 122.6 сая ширхэг гүйлгээг амжилттай хүлээн авсан нь өмнөх улирлын үзүүлэлтээс гүйлгээний дүнгийн хувьд 16.3 хувиар буурсан ч, гүйлгээний тооны хувьд 8.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна (Хүснэгт III, IV).

Төхөөрөмж дээр хийгдсэн нийт гүйлгээг Бэлэн, Бэлэн бус гэж ангилж байгаагаас


өмнөх оны IV улиралд ПОС төхөөрөмжөөр хийгдсэн бэлэн бус гүйлгээний тоо нийт бэлэн бус гүйлгээний тооны 93.7 хувь, гүйлгээний дүнгийн 38.5 хувийг эзэлж байсан бол энэ оны IV улиралд гүйлгээний тооны 95.9, гүйлгээний дүнгийн 48.9 хувь болж өссөнийг Хүснэгт III-ын үзүүлэлтээс харж болно. Өмнөх оны IV улиралд ATM/CRM төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний дүн нийт төхөөрөмжөөр хийгдсэн бэлэн бус гүйлгээний дүнгийн хамгийн их буюу 61.2 хувийг эзэлж байсан бол энэ оны IV улиралд 50.7 хувь болж буурсан байна.

Харин АТМ/CRM төхөөрөмж ашиглаж Бэлэнжүүлсэн гүйлгээ нийт гүйлгээний тооны 74.0, дүнгийн 54.5 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны 76.6 ба 55.2 хувиас буурсан байгааг Хүснэгт IV-өөс харж болно. Мөн CDM болон CRM төхөөрөмж дээр бэлнээр хийгдсэн орлогын гүйлгээ нийт бэлэн гүйлгээний 23.7 хувийг, гүйлгээний дүнгийн 43.4 хувийг эзэлж байгаа үзүүлэлт нь өмнөх оныхоос 2.4 ба 1.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. ПОС төхөөрөмж ашиглан бэлэн мөнгө болгох гүйлгээ нь хамгийн бага буюу нийт бэлнээр хийгдсэн гүйлгээний тооны 0.6 хувь, гүйлгээний дүнгийн 0.2 хувийг эзэлж байна. Гүйлгээний тоо ба дүнг төхөөрөмж тус бүрээр авч үзвэл 99.1 сая ширхэг, 2.3 их

наяд төгрөгийн гүйлгээ ПОС төхөөрөмжөөр хийгдсэн нь өмнөх оны IV улирлын гүйлгээний тооноос 23.1 хувь, гүйлгээний дүнгээс 14.8 хувиар өссөн байгаа ч өмнөх буюу III улирлаас гүйлгээний тоо 9.3 хувиар, гүйлгээний дүн 8.0 хувиар буурсан байна. АТМ, CDM, CRM төхөөрөмжүүдээр энэ оны IV улиралд нийт 22.6 сая ширхэг, 6.3 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оноос тооны хувьд 28.4 хувиар, дүнгийн хувьд 23.8 хувиар (Зураг 6), өмнөх III улирлаас гүйлгээний тоо 22.8 хувиар, гүйлгээний дүн 16.8 хувиар тус тус буурсан байна (хавсралтын Хүснэгт 4а,б). Тайлант улиралд ПОБ төхөөрөмжөөр нийт 76.1 тэрбум төгрөгийн 317.3 мянган гүйлгээ хийгдсэн байгаа нь өмнөх оны IV улирлын




үзүүлэлтээс дүнгийн хувьд 36.3, тооны хувьд 24.7 хувиар тус тус буурсан байна. МПОС төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоог өмнөх онтой харьцуулахад 82.0 мянган ширхэгээс 12.3 мянган ширхэг гүйлгээ болж 85.0 хувиар, дүнгийн хувьд 560 сая гүйлгээ болж 58.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Цахим худалдааны хувьд 2019 оны IV улирлаас гүйлгээ 66.9 хувиар, гүйлгээний дүн 53.2 хувиар тус тус өссөнөөр 20.0 тэрбум төгрөгийн 485.2 мянган ширхэг гүйлгээ 2020 оны IV улиралд хийгдээд байна (хавсралтын Хүснэгт 4а,б).



Сүүлийн жилүүдэд бэлэн бус төлбөрийн хэрэгсэлийн хэрэглээ нэмэгдэж байгааг Зураг 7-д үзүүлээ. Бэлэн бус төлбөрийн хэмжээ 2016 онд нийт картын гүйлгээний 55.1 хувийг эзэлж байсан бол 2017 оноос 73.7 болж нэмэгдсээр 2018 онд 72.2 хувь,

2020 оны байдлаар 84.1 хувьд хүрчээ. Харин бэлэн гүйлгээний хэрэглээ 2016 онд картын нийт гүйлгээний 44.9 хувийг эзэлж байсан бол 2017 оноос буурсаар 2018 онд 26.3 хувь, 2020 оны байдлаар 15.9 хувь болсон байна. Энэ нь иргэд төлбөрөө бэлэн бусаар хийх хандлага өссөөр байгааг харуулж байна (хавсралтын Хүснэгт 4а).




Бэлэн бус гүйлгээний хэрэглээ дүнгийн хувьд 2016 онд нийт картын гүйлгээний дүнгийн 44.1 хувийг эзэлж байсан бол 2020 оны байдлаар 54.5 хувьд хүрчээ. Харин бэлнээр хийгдсэн гүйлгээний дүн 2016 онд нийт картын гүйлгээний 55.9 хувийг эзэлж байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 45.5 хувь болж бэлэн бусаар хийгдсэн гүйлгээ дүнгийн хувьд бэлнээр хийгдсэн гүйлгээнээс илүү хувийг эзэлж байгааг Зураг 8-д үзүүлээ.

ҮЦГТ-ын нэгдсэн сүлжээнд 2020 оны IV улиралд хийгдсэн гүйлгээний тоо ба дүнг Худалдаа үйлчилгээний төрлөөр ангилсан хураангуйг Хүснэгт V, VI-аас харж болно. Хүснэгтээс үзэхэд, гүйлгээний тоо ба дүнгийн хувьд, хүнсний дэлгүүр, супермаркет, төрөл бүрийн хүнсний цэгүүд /ТҮЦ/ болон АТМ-д хамгийн их буюу хэрэглэгчдийн дийлэнх гүйлгээ төвлөрч байгааг Хүснэгт V, VI-ийн үзүүлэлтийг хувьчилж Зураг 9 ба 10-д үзүүлэв.


Хүснэгт V. ҮЦГТ-өөр дамжсан картын гүйлгээний дүн худалдаа үйлчилгээнтэй төрлөөр (2020-IV)		
ТОП 15 болон бусад /Гүйлгээний дүнгээр/	КУБ дугаар	Гүйлгээний дүн
1.Хүнсний дэлгүүр, супермаркет	5411	600,254,023,644
2.АТМ-ын гүйлгээ	6011	453,639,390,400
3.Төрөл бүрийн хүнсний цэгүүд /ТҮЦ/	5499	126,493,640,055
4.Шатахуун түгээх газар	5542	90,991,744,027
5.Эм, гоо сайхан, ариун цэврийн барааны дэлгүүр	5912	84,766,508,949
6.Хоолны газар, ресторан	5812	80,827,146,142
7.ПОБ-ын гүйлгээ	6010	64,604,591,332
8.Гэр бүлийн хувцасны дэлгүүр	5651	58,954,749,347
9.Их дэлгүүр	5311	56,240,352,776
10.Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувцасны дэлгүүр	5691	46,328,564,901
11.Эмнэлэг	8062	34,210,314,744
12.Шөнийн цэнгээний газар, паб	5813	30,891,387,681
13.Шатахууны жижиглэн худалдаа /non-automotive/	5983	28,348,103,435
14.Автомашин үйлчилгээний цэгүүд	5541	26,184,409,511
15.Бөөний худалдаа	5300	25,778,636,032
16.Бусад		551,462,585,126
НИЙТ		2,359,976,148,103

Зураг 9. 2020 оны IV улирлын картын гүйлгээний дүнд эзлэх хувь



Хүснэгт VI. ҮЦГТ-өөр дамжсан картын гүйлгээний тоо худалдаа үйлчилгээнтэй төрлөөр (2020-IV)		
ТОП 15 болон бусад /Гүйлгээний тоогоор /	КУБ дугаар	Гүйлгээний тоо
1.Хүнсний дэлгүүр, супермаркет	5411	39,684,381
2.Төрөл бүрийн хүнсний цэгүүд /ҮҮЦ/	5499	9,519,618
3.АТМ-ын гүйлгээ	6011	5,401,761
4.Эм, гоо сайхан, ариун цэврийн барааны дэлгүүр	5912	4,550,598
5.Хоолны газар, ресторан	5812	4,092,690
6.Шатахуун түгээх газар	5542	1,963,371
7.Түргэн хоолны газар	5814	1,462,823
8.Их дэлгүүр	5311	1,307,834
9.Бөөний худалдаа	5300	1,282,282
10.Төрөлжсөн бус барааны дэлгүүр	5331	1,103,715
11.Шөнийн цэнгээний газар, паб	5813	1,004,685
12.Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувцасны дэлгүүр	5691	972,490
13.Гэр бүлийн хувцасны дэлгүүр	5651	885,288
14.Автомашин үйлчилгээний цэгүүд	5541	761,457
15.Шатахууны жижиглэн худалдаа /non-automotive/	5983	704,315
16.Бусад		13,254,487
НИЙТ		87.951.795

Зураг 10. 2020 оны IV улирлын картын гүйлгээний тоонд эзлэх хувь



Залилангийн гүйлгээ.

Тайлант хугацаанд нийт 154 удаагийн үйлдлээр 31.9 сая төгрөгийн залилангийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны IV улиралтай харьцуулахад гүйлгээний тоо 8.9 хувиар, дүн нь 53.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна (хавсралтын Хүснэгт 6а,б,в). Үүнд:

➤ Картын төрлөөр:

1. ₮ карт 41 удаагийн үйлдлээр 5.3 сая төгрөг;
2. Виза карт 90 удаагийн үйлдлээр 42.9 сая төгрөг;
3. ЮнионПэй 25 удаагийн үйлдлээр 11.8 сая төгрөг;
4. Американ экспресс 4 удаагийн үйлдлээр 146.9 мянган төгрөг.

➤ Төхөөрөмжийн төрлөөр:

1. ПОС 20 удаагийн үйлдлээр 1.6 сая төгрөг;
2. АТМ/СRM 54 удаагийн үйлдлээр 16.2 сая төгрөг;
3. Цахим худалдаа 86 удаагийн үйлдлээр 42.5 сая төгрөгийн залилангийн гүйлгээ тус тус хийгдсэн байна (хавсралтын Хүснэгт 6а,б,в). Мөн төхөөрөмж дээр хийгдсэн залилангийн гүйлгээг тоо ба дүнгээр нь ялгаж Зураг 11, 12-д үзүүлэв.

Зураг 11. Залилангийн гүйлгээ - тоогоор /2017-2020/



Зураг 12. Залилангийн гүйлгээ - дүнгээр /2017-2020/



2. ТӨЛБӨРИЙН БУСАД ХЭРЭГСЛИЙН ХЭРЭГЛЭЭ

Тайлант хугацаанд төлбөрийн бусад хэрэгслээр хийгдсэн гүйлгээний тоо, дүнг ангилж үзэхэд дараах үзүүлэлттэй байна. Банкуудын илгээсэн гүйлгээг төлбөрийн хэрэгслээр тодруулбал:

- Бэлэн мөнгө – 4.4 их наяд төгрөгийн 2.2 сая ширхэг;
- Кредит шилжүүлэг – 41.8 их наяд төгрөгийн 12.3 сая ширхэг;
- Мөнгөн гуйвуулга – 19.4 тэрбум төгрөгийн 9.2 мянган ширхэг;
- Гадаад шилжүүлэг (SWIFT) – 4.8 их наяд төгрөгийн 48.8 мянган ширхэг (хавсралтын Хүснэгт 5).

Харин банкуудын хүлээн авсан гүйлгээг төлбөрийн хэрэгслээр задалбал:

- Бэлэн мөнгө – 4.4 их наяд төгрөгийн 2.9 сая ширхэг;
- Мөнгөн гуйвуулга – 54.5 тэрбум төгрөгийн 31.5 мянган ширхэг;
- Гадаад шилжүүлэг (SWIFT) – 4.2 их наяд төгрөгийн 41.8 мянган ширхэг (хавсралтын Хүснэгт 5).

Дээрх үзүүлэлтээс үзэхэд банкан дээр хийгдэж буй харилцагчийн гүйлгээнээс шилжүүлгийн төрөл өмнөх оны үзүүлэлтийн адилаар нийт гүйлгээний тооны хамгийн их буюу 74.5 хувь байсан бол энэ оны IV улиралд 70.3 хувийг, мөн

гүйлгээний дүнгийн 66.5 хувь байсан бол 70.1 хувийг эзэлж байна. Харин мөнгөн гуйвуулга дүнгийн хувьд хамгийн бага буюу 2019 оны IV улиралд нийт гүйлгээний дүнгийн 0.14 хувийг эзэлж байсан бол энэ улиралд 0.03 хувийг, нийт гүйлгээний 0.22 хувь байсан бол 0.05 хувийг тайлант улиралд эзэлж байна.

3. ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧ ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭ


Төлбөрийн системийн оролцогч хоорондын гүйлгээний тооны дийлэнх хувийг бага дүнтэй гүйлгээ, дүнгийн ихэнх хувийг их дүнтэй гүйлгээ тус тус эзэлдэг харьцаа тайлант улиралд хэвээр хадгалагджээ. 2020 оны IV улирлын байдлаар их дүнтэй гүйлгээний (RTGS), бодит цагийн гүйлгээний (RTP), багцын гүйлгээний (ACH) сүлжээгээр нийт 109.5 их наяд төгрөгийн 24.3 сая ширхэг гүйлгээ хийгдсэнээс, нийт гүйлгээний тооны 72.9 хувь буюу 17.7 сая ширхэг бага дүнтэй гүйлгээ (RTP), 25.4 хувь буюу 6.2 сая ширхэг багцын гүйлгээ (ACH), үлдсэн 1.8 хувийг их дүнтэй гүйлгээ эзэлж байна. Харин нийт гүйлгээний дүнгийн 95.4 хувь буюу 104.5 их наяд төгрөгийг их дүнтэй гүйлгээ эзэлж байна. Бага дүнтэй болон багцын гүйлгээ нь нийт гүйлгээний дүнгийн

3.8 болон 0.8 хувийг тус тус эзэлж байна (хавсралтын Хүснэгт 7).

Бага дүнтэй гүйлгээний тоог өмнөх оны мөн энэ үетэй харьцуулахад 606.2 мянган ширхэг буюу 3.5 хувиар, гүйлгээний дүн 422.0 тэрбум төгрөг буюу 11.4 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бол, их дүнтэй гүйлгээний тоо 7.8 мянган ширхэг буюу 1.8 хувиар буурсан ч, гүйлгээний дүн 20.6 их наяд төгрөг буюу 24.6 хувиар өссөн байгааг Зураг 13-аас харж болно.

Зураг 13-д үзүүлснээр 2019 оны I улиралд гүйлгээний дүнгийн хувьд огцом өсөлт гарсан байгаа нь өмнөх тайлангуудад их дүнтэй гүйлгээний тоон мэдээг оруулахдаа зөвхөн арилжааны банкуудын дамжуулсан гүйлгээний тоон мэдээг оруулдаг байсан бөгөөд 2019 оны I улирлаас эхлэн Монголбанкны өөрийн дамжуулсан гүйлгээний тоон мэдээг оруулах болсонтой холбоотойгоор дүнгийн хувьд огцом өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 13. Төлбөрийн системийн оролцогч хоорондын гүйлгээ /2018-2020/



I. ТӨЛБӨРИЙН КАРТЫН ХЭРЭГЛЭЭ

Хүснэгт 1а. Картын хэрэглээний тайлан

(Өссөн дүнгээр)

		2019 он, IV улирал	2020 он, IV улирал	Өсөлт/бууралт (2019-IV-2020-IV)	
				Тоо	Хувь
Картын тоо		3,748,025	4,077,893	329,868	8.80%
Идэвхтэй ашиглагдаж буй картын тоо		1,899,509	1,863,290	(36,219)	-1.91%
Картын тоо	Хотууд	2,571,579	2,687,406	115,827	4.50%
	Бусад аймгууд	1,176,446	1,390,487	214,041	18.19%

Хүснэгт 1б. Картын хэрэглээний тайлан - Аймаг, хотоор

01/10/2020 - 31/12/2020

№	Хот, аймаг	₮ карт		Виза				Мастеркарт				ЮнионПэй				Амекс				ЖейСиБи				Нийт картын тоо
		Энгийн		Энгийн		₮ карттай хосолсон		Энгийн		₮ карттай хосолсон		Энгийн		₮ карттай хосолсон		Энгийн		₮ карттай хосолсон		Энгийн		₮ карттай хосолсон		
		Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	Дебит	Кредит	
1	Улаанбаатар	1,425,895.00	26,568.00	355,840.00	56,846.00	0.00	0.00	90,621.00	2,687.00	21,699.00	0.00	46,650.00	9,623.00	340,561.00	46,237.00	1,377.00	1,998.00	0.00	0.00	4,387.00	0.00	0.00	0.00	2,430,989
2	Дархан-Уул	83,570.00	1,349.00	8,741.00	2,307.00	0.00	0.00	619.00	56.00	376.00	0.00	3,393.00	209.00	22,718.00	2,719.00	143.00	5.00	0.00	0.00	254.00	0.00	0.00	0.00	126,459
3	Орхон	84,230.00	988.00	11,747.00	2,415.00	0.00	0.00	682.00	87.00	378.00	0.00	3,530.00	386.00	23,031.00	1,975.00	137.00	21.00	0.00	0.00	351.00	0.00	0.00	0.00	129,958
Нийт (дээрх хотууд)		1,593,695	28,905	376,328	61,568	0	0	91,922	2,830	22,453	0	53,573	10,218	386,310	50,931	1,657	2,024	0	0	4,992	0	0	0	2,687,406
Нийт эзлэх %		62.54%		84.37%				94.98%				60.51%				89.78%				57.21%				65.90%
4.00	Бусад аймгууд	954,171.00	17,829.00	67,835.00	13,311.00	0.00	0.00	3,888.00	445.00	1,865.00	0.00	48,078.00	3,445.00	272,818.00	2,649.00	365.00	54.00	0.00	0.00	3,734.00	0.00	0.00	0.00	1,390,487
Нийт эзлэх %		37.46%		15.63%				5.02%				39.49%				10.22%				42.79%				34.10%
Нийт (Улс)		2,547,866	46,734	444,163	74,879	0	0	95,810	3,275	24,318	0	101,651	13,663	659,128	53,580	2,022	2,078	0	0	8,726	0	0	0	4,077,893
Нийт (Улс)		2,594,600		519,042				123,403				828,022				4,100				8,726				4,077,893

Хүснэгт 1в. Карт эзэмшигч - Нэр төрлөөр

2017 - 2020 он (картын тоо өссөн дүнгээр)

Он	₮ карт	Виза	Мастеркарт	ЮнионПэй	Амекс	ЖейСиБи	Нийт
2017 он, IV улирал	2,801,403	621,150	14,611	394,801	12,429	236	3,844,630
2018 он, IV улирал	3,115,568	680,120	28,379	457,971	7,307	1,808	4,291,153
2019 он, IV улирал	2,600,808	392,747	76,255	664,563	4,464	9,188	3,748,025
2020 он, IV улирал	2,594,600	519,042	123,403	828,022	4,100	8,726	4,077,893
Өсөлт/бууралт (2020-IV)	(6,208.00)	126,295.00	47,148.00	163,459.00	(364.00)	(462.00)	329,868.00
Өсөлт/бууралт хувиар (2020-IV)	-0.24%	32.16%	61.83%	24.60%	-8.15%	-5.03%	8.80%
Нийт зах зээлд эзлэх хувь	63.63%	12.73%	3.03%	20.31%	0.10%	0.21%	100.00%

Хүснэгт 2а. Төхөөрөмжийн хэрэглээний тайлан - Аймаг, хотоор

01/10/2020 - 31/12/2020

№	Хот, аймаг	ПОС	МПОС	ПОБ	АТМ	CDM	CRM	Цахим худалдаа	"КИОСК (пос-той)"	Бусад	Нийт
1	Улаанбаатар	50,158.00	1,845.00	1,426.00	681.00	28.00	1,144.00	1,101.00	228.00	0.00	56,611
2	Дархан-Уул	1,949.00	120.00	80.00	48.00	4.00	39.00	3.00	4.00	0.00	2,247
3	Орхон	1,774.00	3.00	71.00	44.00	1.00	42.00	0.00	8.00	0.00	1,943
Нийт (Хотууд)		53,881	1,968	1,577	773	33	1,225	1,104	240	0	60,801
Нийт эзлэх %		76.15%	96.66%	54.10%	71.31%	78.57%	76.80%	99.28%	90.91%	0	76.19%
4	Бусад аймаг	16,872.00	68.00	1,338.00	311.00	9.00	370.00	8.00	24.00	0.00	19,000
Нийт эзлэх %		23.85%	3.34%	45.90%	28.69%	21.43%	23.20%	0.72%	9.09%	0	23.81%
Нийт (Улс)		70,753	2,036	2,915	1,084	42	1,595	1,112	264	0	79,801

Хүснэгт 2б. Төхөөрөмжийн тоо

2018 - 2020 он (төхөөрөмжийн тоо өссөн дүнгээр)

Төхөөрөмж		2018 он, IV улирал	2019 он, IV улирал	2020 он, IV улирал	Өсөлт/бууралт (2019-IV/2020-IV)		Нийт төхөөрөмжид эзлэх хувь
					Тоогоор	Хувиар	
1	ПОС	42,014	59,703	70,753	11,050	18.51%	88.66%
2	МПОС	3,784	2,803	2,036	-767	-27.36%	2.55%
3	ПОБ	2,177	2,242	2,915	673	30.02%	3.65%
4	АТМ	2,358	1,259	1,084	-175	-13.90%	1.36%
5	CDM	0	388	42	-346	-89.18%	0.05%
6	CRM	0	1,674	1,595	-79	-4.72%	2.00%
7	Цахим худалдаа	0	773	1,112	339	43.86%	1.39%
8	"КИОСК (пос-той)"	0	163	264	101	61.96%	0.33%
9	Бусад	0	0	0	0	0	0.00%
Нийт		50,333	69,005	79,801	10,796	15.65%	100.00%

Хүснэгт 3а. Өөрийн гаргасан картыг өөрийн сүлжээнд хүлээж авсан амжилттай гүйлгээний тайлан - Картын төрлөөр

01/10/2020 - 31/12/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

	₮ карт		Виза		Мастеркарт		ЮнионПэй		Амекс		ЖэйСиБи		Нийт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийт	39,331.92	3,812.10	7,033.23	1,344.79	470.49	29.38	14,918.09	1,653.09	26.66	5.28	14.56	1.36	61,794.95	6,846.00

Хүснэгт 3б. Өөрийн гаргасан картаар нэгдсэн, гадаад сүлжээнд хүлээж авсан амжилттай гүйлгээний тайлан - Төхөөрөмжийн төрлөөр

01/10/2020 - 31/12/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

№	Хүлээн авагч төхөөрөмж	Нэгдсэн сүлжээ												Гадаад сүлжээ										Нийт	
		₮ карт		Виза		Мастеркарт		ЮнионПэй		Амекс		ЖэйСиБи		Виза		Мастеркарт		ЮнионПэй		Амекс		ЖэйСиБи			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ПОС	36,196.68	722.70	8,886.68	291.20	741.73	22.71	12,999.91	299.40	0.00	0.00	51.17	1.04	253.89	45.42	5.57	0.71	6.70	2.53	2.40	1.49	0.48	0.13	59,145.21	1,387.32
2	ПОБ	114.91	25.85	31.34	10.33	0.85	0.18	37.66	9.96	0.00	0.00	0.03	0.01	10.92	2.79	0.00	0.01	0.06	0.59	0.00	0.00	0.00	0.00	195.79	49.72
3	АТМ	1,826.37	210.06	405.46	50.15	58.45	6.56	570.06	62.57	0.00	0.00	6.37	0.90	22.04	19.13	1.11	0.46	7.34	12.90	0.02	0.02	0.05	0.05	2,897.27	362.78
4	Цахим худалдаа	55.63	0.60	30.42	0.79	2.56	0.04	37.46	0.68	0.00	0.00	0.03	0.00	569.33	107.49	150.85	18.12	3.01	0.50	9.19	4.33	0.13	0.01	858.61	132.57
Нийт		38,193.59	959.20	9,353.90	352.47	803.59	29.49	13,645.10	372.61	0.00	0.00	57.61	1.95	856.18	174.84	157.53	19.30	17.11	16.52	11.61	5.84	0.66	0.18	63,096.87	1,932.39

Хүснэгт 4а. Өөрийн сүлжээнд хүлээн авсан амжилттай гүйлгээний тайлан – Төхөөрөмжийн төрлөөр

01/10/2020 - 31/12/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

	Бэлэн бүс										Бэлэн								Нийт	
	ПОС		МПОС		Цахим худалдаа		АТМ/CRM		КИОСК (пос-той)		ПОС		ПОБ		АТМ/CRM зарлага		CDM/CRM орлого			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өөрийн карт	41,410.91	964.85	3.26	0.30	330.01	17.46	3,585.40	2,391.02	36.00	0.84	122.82	6.73	137.27	30.91	11,563.16	1,805.16	4,613.21	1,710.17	61,802.03	6,927.45
Дотоодын бусад байгууллагын карт	57,463.33	1,328.54	9.07	0.26	150.55	2.14	-	-	40.56	0.41	-	-	179.67	43.82	2,821.02	328.60	-	-	60,664.20	1,703.78
Гадаад байгууллагын карт	76.55	10.87	0.00	0.00	4.62	0.37	-	-	0.04	0.00	-	-	0.37	1.35	23.25	14.54	-	-	104.83	27.12
Нийт	98,950.79	2,304.26	12.32	0.56	485.18	19.97	3,585.40	2,391.02	76.60	1.25	122.82	6.73	317.31	76.08	14,407.43	2,148.30	4,613.21	1,710.17	122,571.06	8,658.35

Хүснэгт 46. Төхөөрөмж тус бүрээр хийсэн гүйлгээний дүн, тоо

2019 - 2020 он (мянган ширхэг, тэрбум төгрөг)

№	Төхөөрөмж	Утга	2019 он, IV улирал	2020 он, IV улирал	Өсөлт/бууралт	Өсөлт/бууралт хувиар
1	ПОС	Тоо	80,457.15	99,073.61	18,616.46	23.14%
		Дүн	2,013.00	2,310.99	297.99	14.80%
2	МПОС	Тоо	81.99	12.32	(69.66)	-84.97%
		Дүн	1.37	0.56	(0.81)	-58.86%
3	ПОБ	Тоо	421.11	317.31	(103.80)	-24.65%
		Дүн	119.38	76.08	(43.30)	-36.27%
4	АТМ/CRM/СDM	Тоо	31,586.59	22,606.04	(8,980.55)	-28.43%
		Дүн	8,200.12	6,249.50	(1,950.62)	-23.79%
5	Цахим худалдаа	Тоо	290.73	485.18	194.45	66.89%
		Дүн	13.04	19.97	6.94	53.20%
6	КИОСК (пос-той)	Тоо	73.20	76.60	3.39	4.64%
		Дүн	2.22	1.25	(0.97)	-43.65%
7	Бусад	Тоо	0	0	0	0
		Дүн	0	0	0	0
Нийт (Улс)		Тоо	112,910.77	122,571.06	9,660.29	8.56%
		Дүн	10,349.12	8,658.35	(1,690.77)	-16.34%

Хүснэгт 5. Төлбөрийн картаас бусад хэрэгсэл ашиглан банкны салбар дээр хийгдсэн гүйлгээний тайлан – Илгээсэн ба Хүлээн авснаар

01/10/2020 - 31/12/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

Гүйлгээний төрөл	Бэлэн мөнгө		Кредит шилжүүлэг		Гуйвуулга						Гадаад шилжүүлэг (SWIFT)		Нийт	
					Western Union		Moneygram		Бусад мөнгөн гуйвуулга					
	Тоо	Дүн	Тоо	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Илгээсэн гүйлгээ	2,201.93	4,435.66	12,294.05	41,771.14	0.74	1.03	1.57	3.93	6.89	14.46	48.82	4,776.34	14,554.00	51,002.56
Хүлээн авсан гүйлгээ	2,857.00	4,373.07	0.00	0.00	5.46	9.45	18.37	30.48	7.67	14.61	41.83	4,188.70	2,930.33	8,616.31

Хүснэгт 6а. Төлбөрийн картын залилангийн гүйлгээ - Картын төрлөөр

01/10/2020 - 31/12/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

№		Өөрийн гаргасан карт						Дотоодын бусад банкны гаргасан карт						Гадаадын байгууллагын гаргасан карт					Нийт
		₮ карт	Виза	Мастеркарт	ЮнионПэй	Амекс	ЖэйСиБи	₮ карт	Виза	Мастеркарт	ЮнионПэй	Амекс	ЖэйСиБи	Виза	Мастеркарт	ЮнионПэй	Амекс	ЖэйСиБи	
1	Тоо	0.028	0.111	0.000	0.003	0.000	0.000	0.006	0.005	0.000	0.001	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.154
2	Дүн	0.005	0.024	0.000	0.001	0.000	0.000	0.001	0.001	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.032

Хүснэгт 6б. Төлбөрийн картын залилангийн гүйлгээ - Төхөөрөмжийн төрлөөр

01/10/2020 - 31/12/2020

№	Байршил	Төхөөрөмж	Тоо	Дүн
1	Монгол улс	ПОС	17.00	1,706,224.00
2		МПОС	0.00	0.00
3		АТМ/CRM	23.00	5,659,000.00
4		Цахим худалдаа	0.00	0.00
5	Олон улс	ПОС	0.00	0.00
6		АТМ/CRM	0.00	0.00
7		Цахим худалдаа	114.00	24,496,677.57
Нийт			154.00	31,861,901.57

Хүснэгт 6в. Төлбөрийн картын залилангийн гүйлгээ - Төхөөрөмжийн төрлөөр

2017 - 2020 он (сая төгрөгөөр)

Он	Утга	ПОС	МПОС	АТМ/СRМ	Цахим худалдаа	Бусад	Нийт
2017 он, IV улирал	Тоо	190	0	31	0	0	221
	Дүн	173.10	-	11.60	-	-	184.70
2018 он, IV улирал	Тоо	22	0	50	21	18	111
	Дүн	1.53	-	16.10	3.00	14.00	34.63
2019 он, IV улирал	Тоо	71.00	0	60.00	38.00	0	169
	Дүн	46.87	-	15.54	5.96	-	68.36
2020 он, IV улирал	Тоо	17.00	0.00	23.00	114.00	0	154
	Дүн	1.71	-	5.66	24.50	-	31.86
Өсөлт/бууралт (хувиар)	Тоо	-76.06%	0.00%	-61.67%	200.00%	0.00%	-8.88%
	Дүн	-96.36%	0.00%	-63.58%	311.26%	0.00%	-53.39%

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧ ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭ

Хүснэгт 7. Их, бага дүнтэй гүйлгээний тоо, дүн

2018-2020 он (мянган ширхэг, их наяд төгрөг)

	2018 он				2019 он ⁵				2020 он			
	Тоо	Өөрчлөлт %	Дүн	Өөрчлөлт %	Тоо	Өөрчлөлт %	Дүн	Өөрчлөлт %	Тоо	Өөрчлөлт %	Дүн	Өөрчлөлт %
I улирал	9,295.80		20.00		13,021.60	40.08%	69.10	245.50%	17,375.01	33.43%	67.43	-2.41%
Бодит цагийн гүйлгээ (RTP)	8,808.80	32.3	1.2	44	12,727.40	44.49%	2.50	108.33%	12,599.90	-1.00%	3.05	22.00%
Багцын гүйлгээ (ACH) ⁶									4,454.91		0.23	
Их дүнтэй гүйлгээ (RTGS)	487	29.2	18.8	46.8	294.2	-39.59%	66.60	254.26%	320.20	8.84%	64.15	-3.68%
II улирал	10,992.30		22.80		14,856.30	35.15%	78.15	242.76%	22,014.99	48.19%	84.45	8.06%
Бодит цагийн гүйлгээ (RTP)	10,379.70	47	1.4	48.4	14,474.40	39.45%	3.05	117.86%	15,498.30	7.07%	3.65	19.67%
Багцын гүйлгээ (ACH)									6,113.57		0.64	
Их дүнтэй гүйлгээ (RTGS)	612.6	29.8	21.4	13	381.9	-37.66%	75.10	250.93%	403.12	5.56%	80.16	6.74%
III улирал	10,850.60		19.60		15,114.00	39.29%	74.10	278.06%	24,626.75	62.94%	91.33	23.25%
Бодит цагийн гүйлгээ (RTP)	10,232.20	126.3	1.4	65.5	14,727.20	43.93%	3.20	128.57%	17,435.66	18.39%	4.07	27.19%
Багцын гүйлгээ (ACH)									6,764.71		0.61	
Их дүнтэй гүйлгээ (RTGS)	618.4	29.4	18.2	11.1	386.8	-37.45%	70.90	289.56%	426.38	10.23%	86.65	22.21%
IV улирал	12,898.70		27.70		17,532.40	35.92%	87.60	216.25%	24,302.57	38.62%	109.50	25.00%
Бодит цагийн гүйлгээ (RTP)	12,311.60	107.3	2.1	90.9	17,099.40	38.89%	3.70	76.19%	17,705.55	3.54%	4.12	11.40%
Багцын гүйлгээ (ACH)									6,171.82		0.87	
Их дүнтэй гүйлгээ (RTGS)	587.1	1.9	25.6	34.7	433	-26.25%	83.90	227.73%	425.20	-1.80%	104.51	24.57%
Нийт	44,037.40		90.10		60,524.30	37.44%	308.95	242.90%	88,319.32	45.92%	352.72	14.17%
Бодит цагийн гүйлгээ (RTP)	41,732.30		6.10		59,028.40	41.45%	12.45	104.10%	63,239.41	7.13%	14.89	19.61%
эзлэх хувь	94.77%		6.77%		97.53%		4.03%		71.60%		4.22%	
Багцын гүйлгээ (ACH)	0.00		0.00		0.00		0.00		23,505.01		2.35	
эзлэх хувь	0.00%		0.00%		0.00%		0.00%		26.61%		0.67%	
Их дүнтэй гүйлгээ (RTGS)	2,305.10		84.00		1,495.90	-35.10%	296.50	252.98%	1,574.90	5.28%	335.47	13.14%
эзлэх хувь	5.23%		93.23%		2.47%		95.97%		1.78%		95.11%	

⁵ Өмнөх тайлангуудад их дүнтэй гүйлгээний тоон мэдээг оруулахдаа зөвхөн арилжааны банкуудын дамжуулсан гүйлгээний тоон мэдээг оруулдаг байсан бөгөөд 2019 оны I улирлаас эхлэн Монголбанкны өөрийн дамжуулсан гүйлгээний тоон мэдээг оруулах болсонтой холбоотойгоор дүнгийн хувьд огцом өссөн үзүүлэлттэй байна.

⁶ Багцын гүйлгээ нь нэгж гүйлгээний дүнгийн хязгаарлалт байхгүй тул Бага дүнтэй гүйлгээн дээр бүртгэдэг байсныг 2020 оны II улирлаас эхлэн өөрчилж, ашиглагдаж буй систем тус бүрээр нь ялгаж бүртгэдэг болсон.